

Тунхаглалын эцсийн хувилбар
2019 оны 01 дүгээр сар

УСНББОУС™

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт™

**ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН
ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО
(УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ),
СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН
ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)**

IPSASB

Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™



Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™

Энэхүү баримт бичгийг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ™) боловсруулж, баталсан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахины практикын чанар ба тууштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн засгийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан УСНББОУС-ууд™ ба Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-уудыг гаргадаг.

УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан илтгэл (НЗСТИ)-ийг бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТИ-тэй холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБПУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

УСНББОУСЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах бүтэц болон үйл явцад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо™ (ДНБХ™) дэмжлэг үзүүлдэг.

Зохиогчийн эрх © 2019 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, зөвшөөрлийн талаархи мэдээллийг [18-р хуудаснаас](#) үзнэ үү.

**ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР
ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-
ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР
БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД
(УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)**

АГУУЛГА

	Параграф
Хэсэг I: Хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх урт хугацаат хувь оролцоо (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт)	4
Хэсэг II: Сөрөг нөхөн төлбөр бүхий урьдчилсан төлбөрийн шинжүүд (УСНББОУС 41-ийн Нэмэлт өөрчлөлт)	13

ХЭСЭГ I: ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Зорилго

1. *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо* (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), *Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд* (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ийн Хэсэг I-ийн зорилго нь НББОУСЗ-өөс гаргасан *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо* (НББОУС 28-ын Нэмэлт өөрчлөлт)-ны (2017 оны 10-р сард гаргасан) үр дүнд НББОУС 28, *Хараат Компани ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д хийсэн явцуу цар хүрээний нэмэлт өөрчлөлттэй уялдуулахын тулд УСНББОУС-д нэмэлт өөрчлөлт оруулах явдал юм.

Харгалзан үзсэн УСНББОУС

УСНББОУС-ын Стандарт	Өөрчлөлтийн товч тойм
УСНББОУС 36, <i>Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт</i>	УСНББОУС 41, <i>Санхүүгийн Хэрэглүүр</i> , үүн дотроо түүний үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх урт хугацаат хувь оролцоонд мөрдөнө гэдгийг тодруулж өгөх.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I

УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

20А ба 51Е-51К параграфыг шинээр нэмж, 44-р параграфыг хассан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Өмчийн арга

...

20А. Өмчийн аргыг ашиглан тайлагнадаггүй хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх бусад санхүүгийн хэрэглүүрийн хувьд байгууллага нь УСНББОУС 41-ийг бас мөрдөнө. Үүнд мөн чанарын хувьд, хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх тухайн байгууллагын цэвэр хөрөнгийн нэг хэсгийг бүрдүүлэх урт хугацаат хувь оролцоо хамаарна (41-р параграфыг үзнэ үү). Байгууллага нь энэ Стандартын 41-р параграф болон 43-48-р параграфыг мөрдөхөөс өмнө, ийм урт хугацаат хувь оролцооны хувьд УСНББОУС 41-ийг мөрдөнө. Энэ Стандартыг мөрдсөний үр дүнд урт хугацаат хувь оролцооны дансны үнэд хийх аливаа залруулгыг тухайн байгууллага нь УСНББОУС 41-ийг мөрдөхдөө харгалзан үзэхгүй.

...

Өмчийн аргын хэрэглээ

...

Үнэ цэнийн бууралтын гарз

44. Байгууллага нь цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлдэггүй ба УСНББОУС 41-ийн нар хүрээнд хамаарах уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн бусад хувь оролцооны хувьд УСНББОУС 41-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөнө. [Хасагдсан]

...

Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт

...

51Е. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ээр 20А параграфыг шинээр нэмж, 44-р параграфыг хассан. 51Ж-51К параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа-ны дагуу буцаах горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 41-ийг даган мөрдөнө.

51Ж. УСНББОУС 41-ийг мөрдсөн өдрөөс эхлэн 51Е параграфт дурдсан нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж буй байгууллага нь 20А параграфт заасан, урт хугацаат хувь оролцоонд УСНББОУС 41-ийн шилжилтийн үеийн шаардлагуудыг мөрдөнө.

51И. УСНББОУС 41-ийг анх мөрдсөний дараа 51Е параграфт дурдсан нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж буй байгууллага нь 20А параграфт заасан шаардлагуудыг урт хугацаат хувь оролцоонд мөрдөхөд хамааралтай УСНББОУС 41-ийн шилжилтийн үеийн шаардлагуудыг мөрдөнө. Энэ зорилгын хувьд УСНББОУС 41-д заасан, анх мөрдөх өдөр гэсэн хэллэгийг тэдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг тухайн байгууллага анх удаа мөрдсөн тайлант жилийн эхэн (нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдсөн өдөр) гэж ойлгож үнших хэрэгтэй. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн даган мөрдөлтийг тусгахын тулд өмнөх тайлант үеүдийг дахин илэрхийлэх шаардлагагүй юм. Үр дагаврын талаархи мэдлэгийг ашиглахгүйгээр дахин илэрхийлэх боломжтой зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин илэрхийлж болох юм.

51К. Хэрэв байгууллага нь 51И параграфыг мөрдсөнөөр өмнөх тайлант үеүдийг дахин илэрхийлээгүй бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдсөн өдөр тухайн байгууллага нь дараах зүйлсийн хоорондох аливаа зөрүүг хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд (эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийн аль тохиромжтойд) хүлээн зөвшөөрнө:

(а) 20А параграфт дурдсан, урт хугацаат хувь оролцооны тухайн өдрөөрх өмнөх дансны үнэ; ба

(б) Тэдгээр урт хугацаат хувь оролцооны тухайн өдрөөрх дансны үнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ийн үр дүнд УСНББОУС 36-д хийсэн хянан засварлалт

ДҮҮ20. УСНББОУСЗ нь 2017 оны 10-р сард НББОУСЗ-өөс гаргасан, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо (НББОУС 28-ын Нэмэлт өөрчлөлт)-д тусгагдсан НББОУС 28, Хараат Компани ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-ын хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУСЗ-ийн ийм нэмэлт өөрчлөлтүүд хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзээд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй санал нэгдсэн.

...

Үлгэрчилсэн жишээ - Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо

Энэхүү жишээ нь УСНББОУС 36-г дагалдах боловч түүний салингүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Мөн чанарын хувьд хараат байгууллага дахь цэвэр хөрөнгө оруулалтын (урт хугацаат хувь оролцооны) нэг хэсгийг бүрдүүлэх урт хугацаат хувь оролцоог байгууллага (хөрөнгө оруулагч) нь тухайн толилуулсан төсөөллүүдэд үндэслэн УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр* ба УСНББОУС 36-гийн дагуу хэрхэн тайлагнахыг үлгэрчлэн харуулах таамагласан нөхцөл байдлыг энэхүү жишээнд тусгасан болно. Байгууллага нь урт хугацаат хувь оролцоог тайлагнахдаа УСНББОУС 41-ийг мөрддөг. Урт хугацаат хувь оролцоог агуулсан, хараат байгууллага дахь өөрийн цэвэр хөрөнгө оруулалтын хувьд байгууллага нь УСНББОУС 36-г мөрдөнө. Энэ жишээн дэх шинжилгээ нь УСНББОУС 36-гийн шаардлагуудыг даган мөрдөж болох цорын ганц арга маягийг харуулах санаа зорилгогүй болно.

Төсөөллүүд

Хөрөнгө оруулагч нь хараат байгууллагад дараах гурван төрлийн хувь оролцоотой байна:

- (а) Р хувьцаа – 40 хувийн өмчлөлийн хувь оролцоог илэрхийлэх энгийн хувьцаа. Хөрөнгө оруулагч нь үүнд өмчийн аргыг хэрэглэдэг. Гурван хувь оролцооны хөрвөх чадварын хувьд тэдгээрийн тус тусын тэргүүн ээлжийн эрхэд үндэслэн авч үзвэл энэхүү хувь оролцоо нь дарааллын хамгийн сүүлд байна.
- (б) С хувьцаа – Хараат байгууллага дахь цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх, хуримтлалгүй давуу эрхийн хувьцаа. Хөрөнгө оруулагч нь үүнийг УСНББОУС 41-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг.
- (в) УХ зээл - Хараат байгууллага дахь цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх, урт хугацаат зээл. Хөрөнгө оруулагч нь жилийн 5 хувийн тогтоосон хүү ба үр ашигт хүүгээр энэхүү хувь оролцоог УСНББОУС 41-ийн дагуу хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хараат байгууллага нь тухайн хөрөнгө оруулагчид жил бүр зөвхөн хүүний төлбөрийг төлдөг. УХ зээл нь эдгээр гурван хувь оролцооноос хамгийн тэргүүн ээлжийн эрхтэй юм.

УХ зээл нь үүсгэн гаргасан, зээлийн үнэ цэнийн бууралттай зээл биш юм. Үлгэрчлэн харуулсан тэдгээр жилүүдийн туршид тухайн хараат байгууллага дахь цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнэ нь УСНББОУС 36-гийн дагуу буурсан эсвэл УХ зээл нь УСНББОУС 41-ийн дагуу зээлийн үнэ цэнийн бууралттай болсон гэсэн ямар нэг бодитой нотолгоо байгаагүй.

УСНББОУС 36-гийн 40-р параграфт заасанчлан, хараат байгууллага нь өмч гэж ангилах ямар нэг хуримтлалтай, эргэлтэнд гаргасан давуу эрхийн хувьцаа байгаагүй. Үлгэрчлэн харуулсан тэдгээр жилүүдийн туршид тухайн хараат байгууллага нь Р эсвэл С хувьцааны хувьд ямар нэг ногдол ашиг зарлаагүй, төлөөгүй.

УСНББОУС 36-гийн 42-р параграфт заасанчлан, хөрөнгө оруулагч нь уг хараат байгууллагын өмнөөс аливаа гэрээний буюу гэрээний бус үүрэг хүлээхгүй, мөн ямар нэг төлбөр төлөхгүй. Иймээс тухайн хараат байгууллага дахь түүний цэвэр хөрөнгө оруулалтын дансны үнэ нь тэг (0) хүртэл буурсан ч гэсэн хөрөнгө оруулагч нь уг хараат байгууллагын алдагдлын хувьд өөрт хамаарах хувь хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй.

Тухайн хөрөнгө оруулагчийн оруулсан анхны хөрөнгө оруулалтын дүн нь Р хувьцаанд 200ТН¹, С хувьцаанд 100ТН, УХ зээлд 100ТН байсан. Хөрөнгө оруулалтыг олж эзэмших үед тухайн хөрөнгө оруулалтын өртөг нь уг хараат байгууллагын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн цэвэр бодит үнэ цэнэ дэх тэрхүү хөрөнгө оруулагчийн хувь оролцоотой тэнцүү байсан.

УСНББОУС 41-ийн дагуух боловч УСНББОУС 36-г мөрдөхийн өмнөх С хувьцаа болон УХ зээлийн тайлант жил бүрийн эцэс дэх дансны үнэ, уг хараат байгууллагын жил тутмын ашиг (алдагдал)-ийг дараах хүснэгтэнд

¹ Энэхүү үлгэрчилсэн жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН) гэж тэмдэглэсэн.

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

товчоолон харуулав. УХ зээлийн үлдэгдлийг түүний алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр харуулсан болно.

<u>Жилийн эцэст</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух С хувьцаа (бодит үнэ цэнэ)</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух УХ зээл (хорогдуулсан өртөг)</u>	<u>Хараат байгууллагын ашиг (алдагдал)</u>
Жил 1	110 ТН	90 ТН	50 ТН
Жил 2	90 ТН	70 ТН	(200) ТН
Жил 3	50 ТН	50 ТН	(500) ТН
Жил 4	40 ТН	50 ТН	(150) ТН
Жил 5	60 ТН	60 ТН	-
Жил 6	80 ТН	70 ТН	500 ТН
Жил 7	110 ТН	90 ТН	500 ТН

Шинжилгээ

Жил 1

Хөрөнгө оруулагч нь Жил 1-д дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт:

<u>Дебит</u>	<u>Р хувьцаа</u>	<u>200 ТН</u>	
<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>100 ТН</u>	
<u>Дебит</u>	<u>УХ зээл</u>	<u>100 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Мөнгө</u>		<u>400 ТН</u>

Хараат байгууллага дахь анхны хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>10 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>10 ТН</u>

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (110ТН-100ТН) хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>Ашиг, алдагдал</u>	<u>10 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Алдагдлын хасагдуулга (УХ зээл)</u>		<u>10 ТН</u>

Алдагдлын хасагдуулгын нэмэгдэлтийг (90ТН-100ТН) хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>Р хувьцаа</u>	<u>20 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>20 ТН</u>

Хараат байгууллагын ашиг дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог (50ТНх40%) хүлээн зөвшөөрөх.

Жил 1-ийн эцэст Р хувьцааны дансны үнэ нь 220ТН, С хувьцааны дансны үнэ 110ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 90ТН байсан.

Жил 2

Хөрөнгө оруулагч нь Жил 2-т дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>Ашиг, алдагдал</u>	<u>20 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>С хувьцаа</u>		<u>20 ТН</u>

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (90ТН-110ТН) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Ашиг, алдагдал	20 ТН	
Кредит	Алдагдлын хасагдуулга (УХ зээл)		20 ТН

Алдагдлын хасагдуулгын нэмэгдэлтийг (70ТН-90ТН) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Ашиг, алдагдал	80 ТН	
Кредит	Р хувьцаа		80 ТН

Хараат байгууллагын алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог (200ТНх40%) хүлээн зөвшөөрөх.

Жил 2-ын эцэст Р хувьцааны дансны үнэ нь 140ТН, С хувьцааны дансны үнэ 90ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 70ТН байсан.

Жил 3

УСНББОУС 36-гийн 20А параграфт заасанчлан, хөрөнгө оруулагч нь С хувьцаа болон УХ зээлийн хувьд УСНББОУС 36-гийн 41-р параграфыг мөрдөхөөс өмнө, УСНББОУС 41-ийг баримталж, түүнийг даган мөрдөнө. Иймээс хөрөнгө оруулагч нь Жил 3-т дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Ашиг, алдагдал	40 ТН	
Кредит	С хувьцаа		40 ТН

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (50ТН-90ТН) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Ашиг, алдагдал	20 ТН	
Кредит	Алдагдлын хасагдуулга (УХ зээл)		20 ТН

Алдагдлын хасагдуулгын нэмэгдэлтийг (50ТН-70ТН) хүлээн зөвшөөрөх.

Дебит	Ашиг, алдагдал	200 ТН	
Кредит	Р хувьцаа		140 ТН
Кредит	С хувьцаа		50 ТН
Кредит	УХ зээл		10 ТН

Хараат байгууллагын алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог (500ТН х 40%) УСНББОУС 36-гийн 41-р параграфт заасанчлан, тэргүүн ээлжийн эрхийн буурах дарааллаар хүлээн зөвшөөрөх.

Жил 3-ын эцэст Р хувьцааны дансны үнэ нь 0 ТН, С хувьцааны дансны үнэ 0 ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 40ТН байсан.

Жил 4

Хараат байгууллага дахь өөрийн хувь оролцоонд УСНББОУС 41-г мөрдсөнөөр хөрөнгө оруулагч нь Жил 4-т дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Ашиг, алдагдал	10 ТН	
Кредит	С хувьцаа		10 ТН

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (40ТН-50ТН) хүлээн зөвшөөрөх.

4 дэх жил бодит үнэ цэнийн 10ТН-ийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх нь С хувьцааны дансны үнэ сөрөг тэмдэгтэй 10 ТН болоход хүргэнэ. Иймээс хөрөнгө оруулагч нь уг хараат байгууллагын алдагдлаас С хувьцаанд өмнө нь хуваарилсан хэсгийг буцаахын тулд дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>10 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>10 ТН</u>

Хараат байгууллагын алдагдлаас С хувьцаанд өмнө нь хуваарилсан хэсгийг буцаах.

УСНББОУС 36-гийн 41-р параграфт заасанчлан, хөрөнгө оруулагч нь тухайн хараат байгууллагын алдагдлын хувьд хүлээн зөвшөөрөлтийг 40ТН-ээр хязгаарлана, яагаад гэвэл ингэснээр уг хараат байгууллага дахь түүний цэвэр хөрөнгө оруулалтын дансны үнэ нь тэг (0) болох юм. Иймээс хөрөнгө оруулагч нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>Ашиг, алдагдал</u>	<u>40 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>УХ зээл</u>		<u>40 ТН</u>

Хараат байгууллагын алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог хүлээн зөвшөөрөх.

Жил 4-ийн эцэст Р хувьцааны дансны үнэ нь 0 ТН, С хувьцааны дансны үнэ 0 ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 0 ТН байсан. Мөн хараат байгууллагын алдагдлаас хүлээн зөвшөөрөөгүй хувь оролцоо нь 30 ТН (хараат байгууллагын хуримтлагдсан алдагдлаас тухайн хөрөнгө оруулагчид хамаарах хувь хэсэг 340ТН – хуримтлагдсан байдлаар хүлээн зөвшөөрсөн алдагдал 320 ТН + буцаасан алдагдал 10 ТН) байсан.

Жил 5

Хараат байгууллага дахь өөрийн хувь оролцоонд УСНББОУС 41-г мөрдсөнөөр хөрөнгө оруулагч нь Жил 5-д дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>20 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>20 ТН</u>

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (60ТН-40ТН) хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>Алдагдлын хасагдуулга (УХ зээл)</u>	<u>10 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>10 ТН</u>

Алдагдлын хасагдуулгын бууралтыг (60ТН-50ТН) хүлээн зөвшөөрөх.

С хувьцаа ба УХ зээлд УСНББОУС 41-ийг мөрдсөний дараа, эдгээр хувь оролцоо нь эерэг дансны үнэтэй болно. Иймээс хөрөнгө оруулагч нь уг хараат байгууллагын алдагдлаас өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан 30 ТН-ийг эдгээр хувь оролцоонд хуваарилна.

<u>Дебит</u>	<u>Ашиг, алдагдал</u>	<u>30 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>С хувьцаа</u>		<u>20 ТН</u>
<u>Кредит</u>	<u>УХ зээл</u>		<u>10 ТН</u>

Хараат байгууллагын алдагдлаас өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан хувь хэсгийг хүлээн зөвшөөрөх.

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Жил 5-ын эцэст Р хувьцааны дансны үнэ нь 0 ТН, С хувьцааны дансны үнэ 0 ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 0 ТН байсан.

Жил 6

Хараат байгууллага дахь өөрийн хувь оролцоонд УСНББОУС 41-г мөрдсөнөөр хөрөнгө оруулагч нь Жил 6-д дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>20 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>20 ТН</u>

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (80ТН-60ТН) хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>Алдагдлын хасагдуулга (УХ зээл)</u>	<u>10 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>10 ТН</u>

Алдагдлын хасагдуулгын бууралтыг (70ТН-60ТН) хүлээн зөвшөөрөх.

Хөрөнгө оруулагч нь хараат байгууллагын ашгийг хувь оролцоо нэг бүрд тэргүүн ээлжийн эрхийн дарааллаар хуваарилдаг. С хувьцаа ба УХ зээлд өмчийн аргын дагуу өмнө нь хуваарилсан алдагдлын дүнгээр, энэ жишээнд эдгээр хувь оролцоонд хуваарилсан дүн 60ТН-ээр уг хөрөнгө оруулагч нь эдгээр хувь оролцоонд хуваарилагдах тухайн хараат байгууллагын ашгийн дүнг хязгаарладаг.

<u>Дебит</u>	<u>Р хувьцаа</u>	<u>80 ТН</u>	
<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>60 ТН</u>	
<u>Дебит</u>	<u>УХ зээл</u>	<u>60 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>200 ТН</u>

Хараат байгууллагын ашиг дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог (500ТНх40%) хүлээн зөвшөөрөх.

Жил 6-гийн эцэст Р хувьцааны дансны үнэ нь 80 ТН, С хувьцааны дансны үнэ 80 ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 70 ТН байсан.

Хөрөнгө оруулагч нь Жил 7-д дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>С хувьцаа</u>	<u>30 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>30 ТН</u>

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (110ТН-80ТН) хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>Алдагдлын хасагдуулга (УХ зээл)</u>	<u>20 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>20 ТН</u>

Алдагдлын хасагдуулгын бууралтыг (90ТН-70ТН) хүлээн зөвшөөрөх.

<u>Дебит</u>	<u>Р хувьцаа</u>	<u>200 ТН</u>	
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>		<u>200 ТН</u>

Хараат байгууллагын ашиг дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог (500ТНх40%) хүлээн зөвшөөрөх.

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Жил 7-гийн эцэст Р хувьцааны дансны үнэ нь 280ТН, С хувьцааны дансны үнэ 110ТН, УХ зээлийн дансны үнэ (алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүн) нь 90ТН байсан.

Жил 1-7

УХ зээлийн хувьд хүүний орлогыг жил бүр хүлээн зөвшөөрдөг тохиолдолд хөрөнгө оруулагч нь УСНББОУС 36-г (УСНББОУС 36-гийн 20А параграф) мөрдсөнөөр үүссэн, УХ зээлийн дансны үнийн аливаа залруулгыг харгалзан үзэхгүй. Иймээс хөрөнгө оруулагч нь жил бүр дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

<u>Дебит</u>	<u>Мөнгө</u>	<u>5 ТН</u>
<u>Кредит</u>	<u>Ашиг, алдагдал</u>	<u>5 ТН</u>

5 хувийн үр ашигт хүүний түвшинд үндэслэн УХ зээлийн хувьд хүүний орлогыг хүлээн зөвшөөрөх.

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн товчоо

Хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг доорх хүснэгтэнд товчоолон харуулав.

<u>Хүлээн зөвшөөрсөн зүйлс</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух үнэ цэнийн бууралт (алдагдал), үүн дотроо түүний буцаалт</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух С хувьцааны олз (гарз)</u>	<u>Өмчийн аргыг мөрдсөнөөр хүлээн зөвшөөрсөн үг хараат байгууллагын ашиг (алдагдал)-ын хувь хэсэг</u>	<u>УСНББОУС 41-ийн дагуух хүүний орлого</u>
<u>Тайлант үе</u>				
<u>Жил 1</u>	<u>(10) ТН</u>	<u>10 ТН</u>	<u>20 ТН</u>	<u>5 ТН</u>
<u>Жил 2</u>	<u>(20) ТН</u>	<u>(20) ТН</u>	<u>(80) ТН</u>	<u>5 ТН</u>
<u>Жил 3</u>	<u>(20) ТН</u>	<u>(40) ТН</u>	<u>(200) ТН</u>	<u>5 ТН</u>
<u>Жил 4</u>	<u>-</u>	<u>(10) ТН</u>	<u>(30) ТН</u>	<u>5 ТН</u>
<u>Жил 5</u>	<u>10 ТН</u>	<u>20 ТН</u>	<u>(30) ТН</u>	<u>5 ТН</u>
<u>Жил 6</u>	<u>10 ТН</u>	<u>20 ТН</u>	<u>200 ТН</u>	<u>5 ТН</u>
<u>Жил 7</u>	<u>20 ТН</u>	<u>30 ТН</u>	<u>200 ТН</u>	<u>5 ТН</u>

ХЭСЭГ II: СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Зорилго

2. *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо* (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), *Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд* (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ийн Хэсэг II-ийн зорилго нь НББОУСЗ-өөс гаргасан *Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд* (СТОУС 9-ийн Нэмэлт өөрчлөлт)-ийн (2017 оны 10-р сард гаргасан) үр дүнд СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-т хийсэн явцуу цар хүрээний нэмэлт өөрчлөлттэй уялдуулахын тулд УСНББОУС-д нэмэлт өөрчлөлт оруулах явдал юм.

УСНББОУС-ын Стандарт	Санал болгосон өөрчлөлтийн товч тойм
УСНББОУС 41, <i>Санхүүгийн Хэрэглүүр</i>	Гэрээний эрт дуусгавар болголтын хувьд зохих сөрөг нөхөн төлбөр үүсэхэд хүргэж болох, урьдчилсан төлбөрийн шинжүүд бүхий тодорхой нэг санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шалгуурыг хангах байдлаар уг ангиллын шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулах.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II

УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-т оруулсан нэмэлт өөрчлөлт

156А, 184-189, МЗУ74А параграфыг шинээр нэмж, МЗУ73(б), МЗУ74(б) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. МЗУ72-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулаагүй боловч харахад хялбар болгох үүднээс энд тусгасан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

156А. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ээр 184-189, МЗУ74А параграфыг шинээр нэмж, МЗУ73(б), МЗУ74(б) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх жилийн тайлант үеүдэд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь дурдсан хугацаанаас өмнөх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

Шилжилт

...

Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүдэд шилжилт

184. 185-189-р параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд байгууллага нь Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ийг УСНББОУС 3-ын дагуу буцаах горимоор мөрдөнө.

185. Энэ Стандартыг анх мөрдсөн тухайн нэг хугацаанаас эхлэн эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж буй байгууллага нь 186-189-р параграфын оронд 157-183-р параграфыг мөрдөнө.

186. Энэ Стандартыг анх мөрдсөний дараа, эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж буй байгууллага нь 186-189-р параграфыг мөрдөнө. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхөд шаардлагатай, энэ Стандартын шилжилтийн үеийн бусад шаардлагуудыг бас мөрдөнө. Энэ зорилгын хувьд анх мөрдөх өдөр гэсэн хэллэгийг тэдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг тухайн байгууллага анх удаа мөрдсөн тайлант үеийн эхэн (нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдсөн өдөр) гэж ойлгож унших хэрэгтэй.

187. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах тохиолдолд:

(a) байгууллага нь санхүүгийн хөрөнгийг 44-р параграфт заасан нөхцлийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж өмнө нь ангилж байсан боловч эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөний үр дүнд тэрхүү нөхцлийг цаашид хангахгүй болсон бол тухайн санхүүгийн хөрөнгийн ийм өмнөх ангиллыг хүчингүй болгоно;

(б) санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах 44-р параграфт заасан нөхцөл өмнө нь хангагдахгүй байсан боловч эдгээр

нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөний үр дүнд тэрхүү нөхцлийг одоо хангахаар болсон бол байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ингэж ангилж болох юм;

(в) байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг 46(а) параграфт заасан нөхцлийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж өмнө нь ангилж байсан боловч эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөний үр дүнд тэрхүү нөхцлийг цаашид хангахгүй болсон бол тухайн санхүүгийн өр төлбөрийн ийм өмнөх ангиллыг хүчингүй болгоно;

(г) санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах 46(а) параграфт заасан нөхцөл өмнө нь хангагдахгүй байсан боловч эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөний үр дүнд тэрхүү нөхцлийг одоо хангахаар болсон бол байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг ингэж ангилж болох юм.

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдөх өдрөөр оршин байгаа баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн ийм ангилал болон хүчингүй болголтыг хийнэ. Уг ангиллыг буцаах горимоор мөрдөнө.

188. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн мөрдөлтийг тусгахын тулд байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнах шаардлагагүй юм. Үр дагаврын талаархи мэдлэгийг ашиглахгүйгээр дахин тайлагнах боломжтой бөгөөд тэрхүү дахин тайлагнасан санхүүгийн тайлан нь энэ Стандартын бүх шаардлагуудыг тусгадаг зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнаж болох юм. Хэрэв байгууллага нь өмнөх тайлант үеүдийг дахин тайлагнаагүй бол тухайн байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн анх мөрдөх өдрийг багтаасан тайлант жилийн эхэн дэх дансны үнэ ба үг өмнөх дансны үнэ хоорондох аливаа зөрүүг эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн анх мөрдөх өдрийг багтаасан тэрхүү тайлант жилийн хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд (эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийн аль тохиромжтойд) хүлээн зөвшөөрнө.

189. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн анх удаа мөрдөх өдрийг багтаасан тухайн тайлант үед байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн үр дүнд нөлөө үзүүлэх санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анги тус бүрийн хувьд тэрхүү анх удаа мөрдөх өдрөөр дараах мэдээллийг тодруулна:

(а) Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхийн яг өмнөх байдлаар тодорхойлсон дансны үнэ ба өмнөх хэмжилтийн ангилал;

(б) Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөний дараа тодорхойлсон шинэ хэмжилтийн ангилал ба дансны үнэ;

(в) Санхүүгийн байдлын тайланд өмнө нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан боловч цаашид ингэж ангилахаа больсон аливаа санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ; ба

(г) Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан эсвэл ингэж ангилахаа больсон шалтгаан.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ хавсралт нь УСНББОУС 41-ийн саллигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Ангилал

Санхүүгийн хөрөнгийн ангилал

...

Үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд зөвхөн болох гэрээний мөнгөн гүйлгээ

...

Гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчилдөг гэрээний нөхцлүүд

МЗУ72. Санхүүгийн хөрөнгө нь гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчилж болох гэрээний нөхцлүүдийг агуулдаг (жишээлбэл; хугацаа дуусахаас өмнө хөрөнгийг урьдчилан төлөх эсвэл хугацааг сунгаж болох) бол тэрхүү гэрээний нөхцлийн улмаас тухайн санхүүгийн хэрэглүүрийн хугацаанд үүсэж болох гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд эсэхийг байгууллага тодорхойлох ёстой. Ингэж тодорхойлохын тулд байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээг өөрчлөхийн өмнө ба өөрчилсөний дараа үүсэж болох гэрээний мөнгөн гүйлгээнүүдийг үнэлэх ёстой. Мөн байгууллага нь гэрээний мөнгөн гүйлгээний хугацаа буюу дүнг өөрчлөх аливаа болзошгүй үйл явдлын шинж чанарыг (өөрөөр хэлбэл, өдөөх үйл явдлыг) үнэлэх шаардлагатай байж болно. Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн болон хүүний төлбөр эсэхийг үнэлэхэд болзошгүй үйл явдлын шинж чанар нь дангаараа тодорхойлогч хүчин зүйл болохгүй боловч түүний шинж тэмдгийн илэрхийлэгч байж болно. Жишээлбэл; хэрэв зээлдэгч нь төлбөрийг хэд хэдэн удаа төлөөгүй бол хүүг арай нэмэгдүүлж, дахин тогтоодог хүүний хувь бүхий санхүүгийн хэрэглүүрийг тохиролцсон өмчийн индекс нь тодорхой түвшинд хүрвэл хүүг арай нэмэгдүүлж, дахин тогтоодог хүүний хувь бүхий санхүүгийн хэрэглүүртэй харьцуулж үзье. Төлөгдөөгүй төлбөрүүд ба зээлийн эрсдлийн нэмэгдэлт хоорондох харилцан хамаарлаас шалтгаалан эхэнд дурдсан санхүүгийн хэрэглүүрийн хувьд уг хэрэглүүрийн хугацаан дахь гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд байх илүү өндөр магадлалтай юм (МЗУ80-р параграфыг бас үзнэ үү).

МЗУ73. Гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөрүүд болоход хүргэх гэрээний нөхцлийн жишээг доор дурдав:

- (a) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, тодорхой хугацааны туршид төлөгдөөгүй байгаа үндсэн дүнтэй холбоотой зээлийн эрсдэл (зөвхөн анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн эрсдлийн төлбөрийг тодорхойлж болох бөгөөд ингэснээр тогтмол дүнтэй байж болно), зээлийн бусад үндсэн эрсдлүүд болон зардал, түүнчлэн ашиг зэрэгт хамаарах төлбөрөөс бүрддэг хувьсах хүүний хувь хэмжээ;
- (б) Өрийн хэрэглүүрийг гаргагч (өөрөөр хэлбэл, зээлдэгч) нь түүний дуусгавар болох хугацаанаас өмнө урьдчилан төлөхийг зөвшөөрдөг эсвэл өрийн хэрэглүүрийг эзэмшигч (өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч) нь уг дуусгавар болохоос хугацаанаас өмнө буцаан өгөхийг зөвшөөрдөг гэрээний нөхцөл бөгөөд тэрхүү урьдчилсан төлбөр нь үндсэн дүнгийн төлөгдөөгүй хэсэг, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүг үндсэндээ илэрхийлэх ба хүү нь тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны зохих нөхөн төлбөрийг багтаасан байж болно;
- (в) Өрийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийг сунгахыг гаргагч эсвэл эзэмшигчид зөвшөөрдөг гэрээний нөхцөл (өөрөөр хэлбэл, сунгах сонголт) бөгөөд сунгах сонголтын ийм нөхцөл нь

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ УРТ ХУГАЦААТ ХУВЬ ОРОЛЦОО (УСНББОУС 36-ГИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ), СӨРӨГ НӨХӨН ТӨЛБӨР БҮХИЙ УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРИЙН ШИНЖҮҮД (УСНББОУС 41-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

тэрхүү сунгалтын хугацаанд үндсэн дүнгийн, түүнчлэн төлөгдөөгүй байгаа үндсэн дүнгээс тооцсон хүүний төлбөр зөвхөн болох гэрээний мөнгөн гүйлгээг үүсгэдэг ба уг хүү нь тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны нэмэлт нөхөн төлбөрийг багтаасан байж болно.

МЗУ74. 40(б) ба 41(б) параграфт заасан нөхцлийг хангах байсан боловч өрийн хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацаанаас өмнө урьдчилж төлөхийг гаргагчид зөвшөөрдөг (эсвэл шаарддаг) эсвэл өрийн хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацаанаас өмнө буцаан өгөхийг эзэмшигчид зөвшөөрдөг (эсвэл шаарддаг) гэрээний зөвхөн тийм нөхцлийн улмаас дээрх параграфуудын нөхцлийг хангахгүй байгаа санхүүгийн хөрөнгийг МЗУ72-р параграфыг үл харгалзан дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шалгуурыг хангана (40(a) параграфт заасан нөхцлийг эсвэл 41(a) параграфт заасан нөхцлийг хангах зүйл) гэж үздэг:

- (a) Байгууллага нь гэрээний нэрлэсэн дүнгээс урамшуулал эсвэл хөнгөлөлт тооцсон дүнгээр санхүүгийн хөрөнгийг олж эзэмшсэн эсвэл үүсгэн гаргасан;
- (б) Урьдчилсан төлбөр нь гэрээний нэрлэсэн дүн болон гэрээний хуримтлагдсан (боловч төлөөгүй) хүүг үндсэндээ илэрхийлэх ба уг хүү нь тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны зохих нөхөн төлбөрийг багтаасан байж болно; ба
- (в) Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед уг урьдчилсан төлбөрийн шинжүүдийн бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц биш байх.

МЗУ74А. МЗУ73(б) ба МЗУ74(б) параграфыг мөрдөх зорилгын хувьд, тухайн гэрээг эрт дуусгавар болгоход хүргэх үйл явдал буюу нөхцөл байдлаас үл хамааран, гэрээний оролцогч тал нь тэрхүү эрт дуусгавар болголтын төлөө зохих нөхөн төлбөрийг төлдөг эсвэл хүлээн авдаг байж болно. Жишээлбэл; гэрээний оролцогч тал нь тухайн гэрээг эрт дуусгавар болгох сонголт хийсэн (эсвэл эрт дуусгавар болголтонд өөр бусад байдлаар хүргэсэн) тохиолдолд зохих нөхөн төлбөрийг төлж эсвэл хүлээн авч болох юм.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 41-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Урт Хугацаат Хувь Оролцоо (УСНББОУС 36-гийн Нэмэлт өөрчлөлт), Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд (УСНББОУС 41-ийн Нэмэлт Өөрчлөлт)-ийн үр дүнд УСНББОУС 41-д хийсэн хянан засварлалт

ДҮУ45. УСНББОУСЗ нь 2017 оны 10-р сард НББОУСЗ-өөс гаргасан, Сөрөг Нөхөн Төлбөр Бүхий Урьдчилсан Төлбөрийн Шинжүүд (СТОУС 9-ийн Нэмэлт өөрчлөлт)-д тусгагдсан СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр-ийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУСЗ-ийн ийм нэмэлт өөрчлөлтүүд хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзээд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй санал нэгдсэн.

ЗОХИОГЧИЙН ЭРХ, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг, Санал Болгосон Практик Удирдамж болон УСНББОУСЗ-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ болон ДНБХ нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘International Public Sector Accounting Standards Board’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл), ‘International Public Sector Accounting Standards’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт), ‘Recommended Practice Guidelines’ (Санал Болгосон Практик Удирдамж), ‘International Federation of Accountants’ (Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо), ‘IPSASB’ (УСНББОУСЗ), ‘IPSAS’ (УСНББОУС), ‘RPG’ (СБПУ), ‘IFAC’ (ДНБХ), ‘IPSASB’ гэсэн лого, ‘IFAC’ гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2019 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. permission@ifac.org хаягаар хандана уу.





**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™**

529 тавдугаар өргөн чөлөө,
Нью Йорк, Нью Йорк 10017
Утас: + 1 (212) 286-9344
Факс: + 1 (212) 286-9570
www.ipsasb.org